



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/172

Мандаловь

Ажлын хэсэг байгуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А-145 дугаар тушаалаар баталсан "Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам"-ын 3.3 дахь хэсэг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 6 дугаар сарын 23-ны А-223 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хулд суманд үржүүлж буй "Нутгийн шилмэл" тэмээнд явуулсан үржил селекцийн ололтийг хянан магадлах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох орон нутгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир (ХОХБТХ-ийн дарга)  
Нарийн бичиг: С.Сүхдорж (Хулд сумын ЗДТГ-ын дарга)  
Гишүүдэд: Б.Мөнхжаргал (ХХААГ-ын дарга)  
Ж.Батбилэг (ХХААГ-ийн МҮА-ны дарга)  
О.Батчулуун (Дэлгэрхангай сумын Засаг дарга)  
Б.Сангад (ХААТ-ийн мэргэжилтэн)  
Ц.Мөнхсүх (ХААТ-ийн мэргэжилтэн)  
Ө.Батсүх (МЭТ-ийн их эмч)  
А.Отгонбаатар (2-р багийн Засаг дарга)

Хоёр. Үржил селекцийн ажлын үр дүнд хянан магадлагаа хийх ажлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, ажлын тайланг аймгийн засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Эрдэнэ-Очир)-д үүрэг болгосугай.

Гурав. Хянан магадлагаа хийхэд шаардагдах зардлыг малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх хэсэгт заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Хулд сумын засаг дарга (Ч.Зоригтбаатар)-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010481